

## ТАНИЛЦУУЛГА

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай УИХ-ын тогтоолын төслийн тухай

“Алсын хараа-2050”, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2020/, “**Ногоон хөгжлийн бодлого**” /УИХ, 2014/, Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “**Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр**”-ийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, **Ус үндэсний хөтөлбөр**”-т “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60 хувьд хамаарах газрын хилийг нарийвчлан тогтоож, улсын болон орон нутгийн хамгаалалтад авна”, “Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улс 2024 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 25%-ийг улсын тусгай хамгаалалтад авах зорилтод дэмжлэг үзүүлнэ” хэмээн тодорхойлсон хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгон улсын тусгай хамгаалалтад авахаар “Газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Энэхүү тогтоолын төсөлд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгохоор улсын тусгай хамгаалалтад авах суурь судалгаа, үндэслэлийг шинжлэх ухааны байгууллагатай хамтран боловсруулж, орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоол гаргуулсан.

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их хурлын тогтоолын төсөлд Хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа, Үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог судалгааг аргачлалын дагуу хийж, яамдуудаас санал авч тусгасан.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны met.gov.mn цахим хуудсанд тогтоолын төслийг нээлттэй байршуулсан болно.

Булган уулыг дархан цаазат газар болгосноор байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрх, түүх, соёлын дурсгалууд, ховор амьтан, ургамал, Гол мөрний урсац бүрэлдэх эх, Ойн сан бүхий газар хамгаалагдах юм.

Дархан цаазат газар болгосноор хамгааллын менежментийг Монгол улсын Засгийн газрын 2006 оны 87 дугаар тогтоолын дагуу Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээтэй уялдуулан орон тоог тогтоох, цалингийн санд өөрчлөлт оруулах замаар Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа хариуцан хэрэгжүүлэх боломжтой.

Тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 1995 оны “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” 26 дугаар тогтоол, тогтоолын холбогдох хавсралтуудад өөрчлөлт орох юм.